

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ЧАНАР, ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН
МЭРГЭЖИЛТЭН ЦЭРЭНДОРЖИЙН БОЛОР-ОЮУНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
Зорилт 1.1. Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.							
1	Арга хэмжээ 1.1.1 БГТ 1.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-Дүн шинжилгээ ний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь.	Дорноговь аймгийн 23 гэрээ бүхий ЭМБ-д чанар төлбөрийн хяналтын дүгнэлтийг танилцуулан мэдээлэл өгсөн.	Цахим өгөгдөл дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	-Аймгийн хэмжээнд ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд 38 эмийн санд чанар төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэн 266,9 мянган төгрөгийн зөрчлийг хяналтаар илрүүлсэн. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр гэрээт 37 эмийн санд гүйцэтгэлийн тоон мэдээллүүд болох нэхэмжилсэн тоо, дүн, цахим хасалтын тоо, дүн, түүврийн тоо, дүн, олгох тоо дүн тус бүрийг тухайн сар бүр танилцуулж мэдээ мэдээллээр ханган, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлж ажилласан. Мөн ТҮБЗХ-ээс хуваарилагдсан түүвэрт 66	2025.01.02 2025.05.19	100

					ЭМБ-ын 2764 тохиолдлын 350,7 сая төгрөгийн гүйцэтгэлээс 739 тохиолдлын 89,2 сая төгрөгийг зөрчлийг хяналтаар илрүүлж хасаж тооцсон байна. Үр дүн: Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийн хувь 100		
2	Арга хэмжээ 1.1.2 БГТ 1.2.4 Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.	Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо	Гэрээт 61 ЭМБ-ыг холбогдох тоон мэдээллээр хангасан.	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээ зохион байгуулсан байна.	ЭМДС-ийн статистик үзүүлэлтийг бэлтгэх, хэвлэх ажлын хэсэгт статистик мэдээллийн эмхэтгэлийг боловсруулахад шаардагдах 2022, 2023, 2024 оны эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардал, эрүүл мэндийн даатгалын хамралтын мэдээ, санхүүгийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг тухай бүр нь хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд гарсан статистик мэдээллийг өдөрлөг арга хэмжээ, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд гарын авлага хэлбэрээр түгээн сурталчлах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үр дүн: Гэрээт 61 эрүүл мэндийн байгууллага статистик тоон мэдээ, мэдээллээр хангалаа.	2025.01.02 2025.05.19	100
3	Арга хэмжээ 1.1.3 “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо -Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажилласан байна.	ЭМДҮЗ-ийн 06 тогтоолыг шинэчлэх ажлын хүрээнд тогтоолын төслийг гэрээт лавлагаа шатлалын 6 ЭМБ, 13 СЭМТ-д хэлтсийн dornogovi.emd@gmail хаягаар болон ЭМБ-уудын тус тусын цахим группт байршуулан, утсаар холбогдож мэдээллийг хүргүүлсэн. БТГ-аас зохион байгуулсан тогтоолын шинэчлэлтэй холбоотой нийт 5 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт аймгийн лавлагаа, анхан шатны ЭМБ-уудыг товлосон хугацаанд утсаар холбогдож бүрэн хамруулсан. Уг сургалтын арга хэмжээнүүдэд 19 ЭМБ-ын 52 удирдлага, эмч, мэргэжилтэн цахимаар хамрагдаж 2025.01.23-ны өдөр шинэчлэн баталсан 04 дүгээр тогтоолын шинэчлэлтэй танилцаж санал бодлоо уламжилсан.	2025.01.02 2025.05.19	100

					- “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн тогтоолын шинэчлэлтэй холбогдуулан 19 ЭМБ-ын гэрээнд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулан батлагдсан төсвийн хүрээнд төсвийн хуваарийг архаг, цочмог, төлөвлөгөөт ОХБ-ээр гаргуулан авч ХАГГ хүргүүлсэн. Шинэчлэгдсэн журмыг хэрэгжилтэд хяналт тавин гэрээт 19 ЭМБ-ыг зөвлөгөө мэдээллээр тухай бүр нь ханган ажиллалаа. Үр дүн: Шинэчлэн батлагдсан 04 дүгээр тогтоолыг 19 ЭМБ хүргүүлэн танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.		
4	Арга хэмжээ 1.1.4 ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	-Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо -Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна	-ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолыг шинэчлэх ажлын хүрээнд тогтоолын журмын төсөл, шийдвэрүүдийг танилцуулах чиглэл хүргүүлэх 2 удаагийн албан бичгийг гэрээт 17 ӨСЭМТ-д цахимаар болон утсаар 1 бүрчлэн холбогдож хүргүүлж танилцуулсан. Мөн БТГ-аас зохион байгуулсан тогтоолын шинэчлэлтэй холбоотой нийт 2 удаагийн сургалтад ЭМГ болон 17 ӨСЭМТ-ийн удирдлага, 56 эмч, мэргэжилтнийг цахимаар хамруулсан. - ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн 2025.01.23-ны өдрийн шинэчлэн баталсан 03 дугаар тогтоолыг хэрэгжүүлж буй нийт 17 анхан шатны ЭМБ-тай 2025 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлуулж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан ХАГГ хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үр дүн: Шинэчлэн батлагдсан 03 дүгээр тогтоолыг 17 ЭМБ хүргүүлэн танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	2025.01.02 2025.05.19	100
5	Арга хэмжээ 1.1.5 Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо,	- Санхүүжүүлсэн мөнгөн	ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ	Аймгийн НЭ, ЗҮНЭ-ийн ЭМДҮЗ-ийн 2025 оны 10 дугаар тогтоолын дагуу “Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг,	2025.01.02 2025.05.19	100

	шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.	дүн -Хамрагдсан даатгуулагч ийн тоо	тогтоолыг мөрдөж байна. 2024 онд 2362 иргэн хамрагдаж 384,2 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	шинжилгээ, оношилгоонд хамрагдсан зорилтот бүлгийн 1325 иргэний 228,1 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт хийж, тайлант хугацаанд 1319 даатгуулагч, иргэнд 226,8 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон. Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний санхүүжилтийн баталгаажуулалтын мэдээг сар бүр ЭМДЕГ-ын СБХ, Аймгийн ЗДТГ, Статистикийн хэлтэс, ЭМГ хүргүүлэн ажилласан. Үр дүн: Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд 1319 даатгуулагч иргэний 226,8 сая төгрөгийг санхүүжилтийг олгохоор тооцон ЭМДЕГ-т хүргүүллээ.		
6	Арга хэмжээ 1.1.6 ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.	Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо	Бодлого төлөвлөлтийн газарт 2 санал хүргүүлсэн	Дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	- ЭМДҮЗ-ийн тогтоолын хэрэгжилт болон ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийн, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон Аймгийн НЭ, ЗҮНЭ-ийн санал бодлыг хүлээн авч зарим архаг ОХБ-ийг цочмог ОХБ-т оруулахтай холбогдох саналыг санал оруулж буй тухайн байгууллагаар нь дамжуулан БТГ-т хүргүүлсэн. Үр дүн: Хүргүүлсэн санал 2	2025.01.02 2025.05.19	100
7	Арга хэмжээ 1.1.7 “ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо -Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	-	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна.	ЭМДҮЗ-ийн 2025 оны 03 дугаар хуралдаанаар баталсан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 11 дүгээр тогтоолыг гэрээт 37 эмийн санд domogovi.emd@gov.mn цахим шуудангаар илгээж, цахим хуудсанд байршуулан, 1 бүрчлэн утасдаж мэдээ, мэдээллийг танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Үр дүн: ЭМДҮЗ-ийн 11 тогтоолыг 37 эмийн санд танилцуулсан.	2025.01.02 2025.05.19	100

	тавин ажиллана.						
Зорилт 1.2 Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно:							
1	Арга хэмжээ 1.2.1 <i>БСТ 2.1.3, БГТ-1.4.3</i> Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.	-Хүргүүлсэн саналын тоо	Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад 3 удаа санал хүргүүлсэн.	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	-“Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журам”-ын төсөл; -ЭМДЕГ, ХХҮЕГ-ын 2025 онд “Хамтран ажиллах гэрээ”-ний төсөл; -Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам”-ын төсөл; -Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчлэн найруулах хуулийн төсөлд тус тус саналаа өгч албан бичгээр ТГ болон БТГ-т хүргүүлсэн. Үр дүн: Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд саналыг 4 удаа хугацаанд хүргүүлсэн.	2025.01.02 2025.05.19	100
Зорилт2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.							
Зорилт 2.1. Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.							
1	Арга хэмжээ 2.1.1 <i>ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1</i> Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт ын хувь	2024 оны хамрагдалт ын хувь 47,1	Малчдын эрүүл мэндийн даатгалд 2025 оны эхний хагас жилд хамрагдалтын хувь 35	-Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд 14 сумаас малчин, оюутан, ХХЭ, ажилгүй болон гадаадын иргэдийн судалгааг авах албан бичгийг боловсруулан хүргэж судалгаа мэдээллийг авч ажилласан. Одоогийн байдлаар судалгаа ирүүлсэн 7 сумын 4087 иргэний хамрагдалтыг health.gov.mn цахим программаас 1 бүрчлэн судалж үзэхэд 41,4%-тай байв. Иймд сумдын Засаг дарга нарт хамралтыг нэмэгдүүлж, хамтран ажиллах албан бичгийг хүргүүлэн ажиллалаа. Мөн АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль болон аймгийн Политехник коллежид суралцагч оюутны судалгааг авах албан бичиг боловсруулан	2025.01.02 2025.05.19 0	100
		Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалт ын хувь	2024 оны хамрагдалт ын хувь 100	Оюутны эрүүл мэндийн даатгалд 2025 оны эхний хагас жилд хамрагдалтын хувь 50			100
		Тодорхой ажил хөдөлмөр	2024 оны хамрагдалт ын хувь 43,8	Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй			100

2		эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь		иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 2025 оны эхний хагас жилд 35 хувь	хүргүүлж хамрагдалтыг судалж үзлээ. Судалгаанд нийт 548 оюутан хамрагдаж хамралт 51,5 хувьтай байсан тул хамрагдалтыг нэмэгдүүлэхэд анхаарч хамтран ажиллах албан бичгийг төлөвлөн хүргүүлсэн. Түүнчлэн аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт цагдан хоригдож байгаа хохирогчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг дэмжин ажиллаж 51 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг шалган, лавлагаа мэдээллийг гарган хүргүүлж 1,2 сая төгрөгийг ЭМДС-д төвлөрүүлсэн байна. Үүний үр дүнд: ✓ Малчин 851 иргэн хамруулахаас 782 иргэн хамрагдаж 92%, ✓ Оюутан 314 иргэн хамруулахаас 1144 иргэн хамрагдаж 364%, ✓ Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй, ХХЭ иргэн 1550 иргэн хамруулахаас 1197 иргэн хамрагдаж 77%, ✓ Гадаадын иргэн, харьяалалгүй хүн 8 хамруулахаас 11 иргэн хамрагдаж 132%-аар тус тус биелсэн. Тайлант хугацаанд 2724 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулахаар төлөвлөгдсөнөөс 3134 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулж 115%-ийн биелэлтэй ажилласан. Үр дүн: Хэрэгжилтийн хувь 100.		
		Байгууллага, аж ахуйн нэгжийн хувь	2024 оны хамрагдалтын хувь 100	-Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь 2024 онд 50 хувь	Тайлант хугацаанд нийт 38 ажил олгогч, даатгуулагчийг эрүүл мэндийн даатгалд хамруулахаас 56 хамрагдаж 147%-ийн биелэлтэй байна. Үр дүн: Хэрэгжилтийн хувь 100.	2025.01.02 2025.05.19	100
	Арга хэмжээ 2.1.2 Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган 2 удаа хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд гэрээт 61 ЭМБ-аас тусламж, үйлчилгээ авсан 136388 /давхардсан тоогоор/ даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардал болон өмнөх оны өглөгт 18,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. ЭМД-ын сангийн зардлын сарын мэдээг 2025	2025.01.02 2025.05.19	100

	хүргүүлнэ.		тавих, тайлан мэдээг гарган жилд 4 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн.		оны 1-3 сарын байдлаар батлагдсан маягтын дагуу үнэн зөв бодит тоон мэдээнд үндэслэн гаргаж СБХ болон аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Статистикийн хэлтэст хугацаанд нь тус тус хүргүүлэн ажилласан. ЭМДС-ын 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг гаргаж ЭМДЕГ-ын Санхүү бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. Үр дүн: Сарын мэдээг 4 байгууллагад 5 удаа, санхүүгийн тайланг 1 удаа гарган хүргүүллээ.		
3	Арга хэмжээ 2.1.3 ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ-2.1.1 Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.	Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 86 хувьтай.	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 44 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын 2025 оны төсвийн хуваарь”-ийн дагуу сангийн орлогын хамрагдалтын төлөвлөгөөг биелэлтийг хангуулах зорилгоор сумдын Засаг дарга болон АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль, аймгийн Политехникийн коллеж, Нийгмийн даатгалын газартай хамтран ажилласан. -Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого 7472,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 5851,2 сая төгрөг биелэлт 78,3%, -Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, оюутан, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдээс 352,0 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 376,9 сая төгрөг төвлөрүүлж 107%-аар тус тус биелэлттэй ажилласан байна. Нийт 7824,0 сая төгрөгийг орлогыг төвлөрүүлэхээс 6228,1 сая төгрөгийг ЭМД-ын санд төвлөрүүлж 80%-ийн гүйцэтгэлтэй ажилласан. Үр дүн: Хэрэгжилтийн хувь 80.	2025.01.02 2025.05.19	80
Зорилт 2.2. Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална.							
1	Арга хэмжээ 2.2.1 БСТ 2.2.1, БГТ-2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага	-Өглөг, авлагын тоо хэмжээ -Тайлан	2024 онд 3,6 тэр бум төгрөгийн өглөгтэй	Өглөг, авлага барагдуулах чигэлээр арга хэмжээ авч	Өмнөх оны 3,6 тэр бум төгрөгийн өглөг, 63,8 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байна. Үр дүн: Хэрэгжилтийн хувь 100.	2025.01.02 2025.05.19	100

	барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.		тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.	ажилласан байна			
Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна							
Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.							
1	Арга хэмжээ 3.1.1 <i>БСТ 3.1.2, БГТ 3.1.1</i> Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.	Гэрээ дүгнүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	2024 онд 61 гэрээт ЭМБ-ыг дүгнэсэн	Гэрээт ЭМБ-уудын гэрээг хагас, бүтэн жилээр хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна.	ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/175 тоот тушаалын дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулж холбогдох баримт бичгийг dornogovi.emd@gov.mn хаягаар хүлээн авч нэгтгэн, батлагдсан журмын хүрээнд жилийн эцсийн байдлаар үнэлж дүгнэн үнэлгээний нэгтгэлийг ХАГГ хүргүүлэн ажилласан. Уг гэрээ дүгнэх арга хэмжээнд гэрээт лавлагаа шатлалын 6 эмнэлэг, 37 эмийн сан, 17 ӨСЭМТ, нийт 61 ЭМБ хамрагдсан. Хангалтгүй үнэлэгдсэн 7 СЭМТ-д улсын ахлах байцаагчийн зөвлөмж, 4 эмийн санд улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг боловсруулан тус тус хүргүүлж, "Төгс охь" эмийн сангийн гэрээг өөрийн хүсэлтээр цуцалсан. Үр дүн: 61 ЭМБ-ын гэрээг үнэлж, дүгнэн холбогдох газарт хүргүүлсэн.	2025.01.02 2025.05.19	100
		Гэрээний хэрэгжилтийн хувь	2024 онд гэрээний хэрэгжилт 80,0	Гэрээний биелэлтийн хувь 90 хувиас доошгүй.	Аймгийн хэмжээнд гэрээт 61 ЭМБ-ын гэрээний хэрэгжилт 80%-тай дүгнэгдсэн. Үр дүн: Хэрэгжилтийн хувь 80.	2025.01.02 2025.05.19	80
2	Арга хэмжээ 3.1.2 2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Өрхийн ЭМТ-4, Сумын ЭМТ-13, Эмийн сан-	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн,	Тайлант онд нийт 60 ЭМБ-тай тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, гэрээг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан ХАГГ-т хүргүүлсэн.	2025.01.02 2025.05.19	100

	авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.		34	шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	-ХАГГ-аас ирүүлсэн 2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг 60 ЭМБ-д тус тус хүргүүлэн ажилласан. Үр дүн: 2025 оны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг 60 ЭМБ-тай байгуулсан.		
3	Арга хэмжээ 3.1.3 Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан	Гэрээт 61 эрүүл мэндийн байгууллагыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан.	Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	2025 оны А/30 дугаар тушаалын “Журам шинэчлэн батлах тухай” журамд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллээр гэрээт лавлагаа шатлалын төрийн өмчит 3, хувийн хэвшлийн 2 эмнэлэг, анхан шатны 17 ӨСЭМТ, нийт 22 ЭМБ-д dornogovi.emd@gmail.com цахим хаягаар хүргэн танилцуулж, мэдээллээр хангасан. Мөн БШУС, ЭМС-ын хамтарсан тушаалын дагуу 6 настны эрт илрүүлэг, шүдний үзлэгийн мэдээллийг гэрээт ЭМБ болон хувийн шүдний эмнэлэгүүдэд танилцуулж 4 сараас эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Үр дүн: Гэрээт 22 ЭМБ Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллээр хангагдсан.	2025.01.02 2025.05.19	100
Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна							
1	Арга хэмжээ 3.2.1 БГТ 3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.	Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн	Нийт 61 ЭМБ-д 34,1 тэр бум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан.	Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг олон улсын эмнэл зүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн журмын дагуу хэрэгжүүлж, 66 лавлагаа шатлалын ЭМБ-ын 3 /яаралтай тусламж, ӨӨОШ, түргэн тусламжийн ойр/ төрлийн тусламж үйлчилгээний 2764 тохиолдлын 350,7 сая төгрөгийн хяналтыг хийсэн байна. Тус хяналтаар 216,6 сая төгрөгийн зардлыг код ахиулсан, шалгуур хангаагүй шалтгаанаар хасаж тооцсон. - Аймгийн хэмжээнд гэрээт 61 эрүүл мэндийн байгууллагын давхардсан тоогоор 136388	2025.01.02 2025.05.19	100

					тохиолдлын 16085,2 сая төгрөгийн гүйцэтгэлийг dga-invoice@emd.gov.mn цахим шуудангаар хүлээн авч нэхэмжлэлийн нарийвчилсан хяналт хийн, хянан баталгаажуулж ажилласан. Үр дүн: 120 ЭМБ-ын 139152 даатгуулагчийн 16435,9 сая төгрөгийн нэхэмжлэлд хяналтыг хийсэн байна.		
2	Арга хэмжээ 3.2.2 БГТ 3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2024 онд 61 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	ЭМДҮЗ-ийн 03, 04, 11-р тогтоолын шинэчлэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг гэрээт лавлагаа шатлалын-6, анхан шатны-17, 38 эмийн санд хүргүүлж, мэргэжил арга зүйгээр тухай бүр ханган, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Үр дүн: Гэрээт 61 ЭМБ-ыг хариуцсан ажлын хүрээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, дэмжлэг үзүүлсэн.	2025.01.02 2025.05.19	100
3	Арга хэмжээ 3.2.3 БСТ 3.2.3, БГТ-3.2.2 Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо -Хяналт шалгалтын айлан	2024 онд гэрээт 5 байгууллагад газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан.	Газар дээрх хяналт, шалгалтхийж тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд иргэний хэргийн Анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчтай хамтран ЭМДС-ийн хохирлыг барагдуулах арга хэмжээний хүрээнд гэм буруутай этгээдээс гаргуулах зардлын мөнгийг иргэн болон ЭМДС-аас давхар нэхэмжилсэн тохиолдлыг хяналт шалгалтаар илрүүлэн 3,1 сая төгрөгийг аймгийн Нэгдсэн эмнэлгээс гаргуулах албан бичгийг хүргүүлсэн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг үнэлсэн байдалд хяналт шалгалт хийх 2025/03 тоот удирдамжийн дагуу ДАХШҮГ-ын холбогдох мэргэжилтэнд баримт материалыг цахим шуудангаар dotood.audit@emd.gov.mn хаягт хүргүүлсэн. Үр дүн: ЭМДС-д 2 хүний 3,1 сая төгрөгийн төвлөрүүлж, 2024 оны гэрээний биелэлтийн үнэлгээнд хийх хяналт шалгалтад холбогдох баримтыг ДАХШҮГ-т хүргүүллээ.	2025.01.02 2025.05.19	100
Зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.							
Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.							

1	Арга хэмжээ 4.1.2 Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо	Зохион байгуулсан арга хэмжээ-4, сургалтын тоо-15	Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах "Эрүүл мэндийн технологи-2025" үзэсгэлэн, "Дорноговь аймаг даатгуулагчдын зөвлөгөөн" арга хэмжээнд оролцож, орлого хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээллээр иргэд, олон нийтийг хангасан. Өдөрлөгийн арга хэмжээний үеэр 100 гаруй иргэнд үйлчилж, эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж ажилласан. Мөн сумдын засаг дарга нарт болон орон нутгийн их дээд сургуулийн захирал нарт хууль тогтоомж, шийдвэр, тухайн нутаг дэвсгэрийн ЭМД-ын хамралтын явцыг уламжилсан албан бичгийг боловсруулан хүргүүлж, орлого хамралтыг нэмэгдүүлсэн. Үр дүн: Төрийн үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангаж орлого хамрагдалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан.	2025.01.02 2025.05.19	100
2	Арга хэмжээ 4.1.3 Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.	Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо	2024 онд 4224 иргэн, даатгуулагчдад мэдээ, мэдээллийг хүргэсэн.	2025 онд 2200-аас доошгүй иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг хүргэсэн байна	Хэлтсийн албан ёсны цахим хаяг "Дорноговь аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс" нэртэй фейсбүүк хуудсыг тогтмол ажиллуулан, эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргэж, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг И-баримт, И-Монголиа аппликейшн ашиглан хэрхэн төлөх болон шалгах, E-Mongolia цахим системээр авсан тусламж үйлчилгээний мэдээллээ хэрхэн харах тухай сурталчилгаа, мэдээллийг 7 хоног бүр тогтмол 3-5 удаагийн давтамжтайгаар нийтэлж, орон нутгийн мэдээллийн нэгдсэн группүүдэд түгээн, давхардсан тоогоор 2700 иргэн, даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн байна. Фейсбүүк хуудасны дагагчдын тоог 552-д хүргэж, 238-р нэмэгдүүлсэн боловч энэхүү цахим хаяг устаж "Дорноговь аймаг-Эрүүл мэндийн даатгалын хэлтэс" фейсбүүк цахим хуудсыг шинээр нээн иргэд даатгуулагчдыг мэдээллээр ханган ажиллаж байна.	2025.01.02 2025.05.19	100

					Түүнчлэн тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим хуудсанд нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг шуурхай түгээж даатгуулагч иргэдийг тогтмол мэдээллээр ханган нийт 450 зурагт постер, 58 удаагийн хөдөлгөөнт постер хэлбэрээр хүргэсэн байна. -Лавлах утсанд ирсэн 222 дуудлага, биечлэн ирсэн 155 нийт 377 даатгуулагч, иргэдийг зөвлөгөө мэдээллээр ханган эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт болон ЭМБ-ын үзүүлж буй тусламж үйлчилгээ, хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн талаарх мэдээллийг олгосон. Үр дүн: Эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 3246 орчим иргэн, даатгуулагчид хүргэсэн байна.		
3	Арга хэмжээ 4.1.4 БГТ 4.1.8 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	322 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.	Сэтгэл ханамжийн судалгаа авч, хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Аймгийн ЭМГ-тай хамтран зохион байгуулсан “Эрүүл мэндийн технологи-2025” үзэсгэлэнд оролцогч иргэдэд “Эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, эрүүл мэндийн даатгалын хувь хэмжээ”-г танилцуулан, 110 иргэнээс сэтгэл ханамжийн судалгааг цахимаар болон цаасаар авч ажилласан. ЭМДЕГ-ын ОНХХ-ээс зохион байгуулж буй эрүүл мэндийн байгууллага, ажилтнуудаас авах, сэтгэл ханамжийн судалгаанд орон нутгийн 60 ЭМБ-ын ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж цахим шуудангаар болон 1 бүрчлэн утсаар холбогдож сэтгэл ханамжийн судалгааг хүргүүлэн хамралтыг нэмэгдүүлсэн. Үр дүн: Хэрэгжилтийн хувь 100	2025.01.02 2025.05.19	100
4	Арга хэмжээ 4.1.5 Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж,	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	Албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийн тоо 12 шийдвэрлэлт 100 хувь.	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт	Тайлант хугацаанд иргэдээс ирүүлсэн нийт 389 өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэн ажилласан. Үүнд: ⬇ Цахимаар -11 ⬇ Лавлах утсаар хандсан-222 ⬇ Биечлэн уулзсан – 144 ⬇ ЭМД-ийн шимтгэл төлөхдөө и-баримт аппликейшнээр давхардуулж төлсөн 12	2025.01.02 2025.05.19	100

	шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.			хүргүүлсэн байна.	өргөдлийг бичгээр гаргасныг хүлээн авч, ЭМДЕГ-ын info@emd.gov.mn цахим хаягаар холбогдох албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлсэн. - Мөн төрийн байгууллагын цахим шуудан болох dornogovi@emd.gov.mn, хэлтсийн цахим dornogovi.emd@gmail.com email хаягаар ирүүлсэн 87 албан бичгийг бүртгэн мэдээллийн сан үүсгэн лавлагаа, мэдээ тайланг хүлээн авч, 116 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн албан хэрэг хөтлөлтийн стандарт заавар журмын дагуу бүртгэлжүүлэн ажилласан. Ирсэн баримт бичгийн шийдвэрлэлтийн биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулж, явцын байдалд байнгын хяналт тавин ажиллалаа. Шийдвэрлээгүй өргөдөл, гомдол, хүсэлт, албан бичиг байхгүй болно. Үр дүн: Тайлант хугацаанд 87 албан бичиг хүлээн авч, хугацаанд нь бүрэн барагдуулж, 116 албан бичиг боловсруулж холбогдох газар хүргүүлж, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ давхардуулж төлсөн 12 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч СБХ-т хүргүүлэн шийдвэрлүүлсэн.		
5	Арга хэмжээ 4.1.6 Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 32 удаа гаргаж хэрэгжилт 100 хувь.	Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Орон нутгийн удирдлага болон хэлтсийн даргын зүгээс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр нь хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнан ажилласан. Үр дүн: Тайлант хугацаанд өгөгдсөн 3 удаагийн үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан.	2025.01.02 2025.05.19	100
6	Арга хэмжээ 4.1.7 Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж,	Архивын нэгжийн тоо (боть)	2023-2024 оны 89 архивын нэгжийг бүрдүүлж,	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хүрээнд хэлтсийн хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу 2023 оны ЭМД-ын сангийн зарлагын анхан шатны баримтууд, ирсэн явсан бичиг, тайлан мэдээ, гэрээ дүгнүүлэхээр	2025.01.02 2025.05.19	100

	архивын нэгж бүрдүүлж, ЭМДЕГ-ын архивт хугацаанд хүлээлгэж өгнө.		албан бичиг хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.	нэгжийг бүрдүүлсэн байна.	ирүүлсэн материалуудыг цэгцлэн архивын 49 нэгж үүсгэн ЭМДЕГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. -2025 оны ЭМД-ын сангийн зарлагын анхан шатны 38 баримтыг нэгж үүсгэсэн. Мөн гэрээт 38 эмийн сангийн хувийн хэргийн иж бүрдлийг шалган нягталж, баяжууллаа. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж байгаа 3 эмийн санд мэдэгдэж сунгалтыг албан бичгээр ЭМДЕГ-т хүргүүлэн health программд сунгалтыг хийлгэлээ. Үр дүн: Архивд 49 боть баримтыг хүлээлгэн өгсөн.		
7	Арга хэмжээ 4.1.8 Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ.	Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо	-	-	ЭМДЕГ-аас зохион байгуулсан able программд мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд тоон гарын үсгийг хэрхэн ашиглах сургалтад хамрагдаж цахим гарын үсгийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн. Тайлант хугацаанд нийт 2 удаагийн албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан холбогдох иргэн, байгууллагуудад хүргүүлж ажилласан. Үр дүн: Тоон гарын үсгээр албан бичиг хүргэгдсэн.	2025.01.02 2025.05.19	100
8	Арга хэмжээ 4.1.9 Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна.	-Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо, - Хэрэгжилтийн хувь	-	-	Төрийн албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулах хуулийн дагуу албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөн 1 удаа хүргүүлсэн. Үр дүн: Тайлант хугацаанд өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэн хос бичгээр албан бичгийг төлөвлөн гаргасан.	2025.01.02 2025.05.19	100
9	Арга хэмжээ 4.1.10 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган	Хэрэгжилтийн хувь	Хуулийн хугацаанд ХАСХОМ, ХАСУМ-ээ	Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт	АТГ-аас зохион байгуулсан "ХАСХОМ-ийн маягтад орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл олгох сургалтад хамрагдаж ХАСХОМ мэдүүлэх аргачлалын талаар мэдлэг,	2025.01.02 2025.05.19	100

	ажиллана		100 хувь мэдүүлсэн байна.	шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна.	мэдээлэлтэй болсон. ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд ЭМДЕГ-ын холбогдох ЭБАТ-ын мэргэжилтэнд хүргүүлсэн. Үр дүн: Хэрэгжилтийн хувь 100.		
--	----------	--	---------------------------	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
	1	2	3	4	5	6	7
1	Эрүүл мэндийн даатгалын шинэчлэгдсэн тогтоол шийдвэрүүдийг тухай бүр нь судалж, танилцан бүрэн мэдлэгтэй болно.	-Сургалтад бүрэн хамрагдсан байна	Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх	Сургалтад бүрэн хамрагдсан байна.	ЭМДҮЗ-ийн баталсан Эрүүл мэндийн даатгалын шинэчлэгдсэн тогтоол шийдвэрүүдийг тухай бүр нь уншин судалж, үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллалаа. Мөн шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдтэй холбоотой БТГ-аас зохион байгуулсан 5 удаагийн сургалтын арга хэмжээнд хамрагдаж мэдлэг, мэдээллээ дээшлүүлсэн.	2025.01.02 2025.05.20	100
2	Арга хэмжээ 4.1.1 БГТ 4.1.4 Ерөнхий газраас баталсан Сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан.	ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг, мэдээлэл авсан	ЭМДЕГ-ын баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй "Мэдээллийн цаг хөтөлбөр"-ийн 5 удаагийн сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг, мэдээллийг олж авсан. Үр дүн: Хэрэгжилтийн хувь 100.	2025.01.02 2025.05.20	100

				байна.			
3	Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.	Нийт 23 удаагийн сургалтад оролцсон.	Хамрагдсан сургалтын тоо	Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна.	Хувь хүний хөгжил", "Төрийн албан хаагчийн ёс зүйн удирдлагын манлайлал" сэдвээр сургалт авах саналыг АЗДТГ-т хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албаны зөвлөлөөс гарсан шинэчлэгдсэн тогтоол, шийдвэр"-ийг танилцуулах онлайн сургалтад хамрагдаж мэдлэг, мэдээллээ дээшлүүлсэн. АЗДТГ-аас зохион байгуулсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан бичих арга зүй", "Ёс зүйн зөрчил, бүртгэл хяналтын дэд системийг ашиглах аргачлал", "Ёс зүйн хорооны ажиллах журам"-ын танилцуулга мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах" сургалтад хамрагдсан	2025.01.02 2025.05.20	100
4	Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах	-	Хамрагдсан сургалтын тоо	Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна.	ЭМДЕГ-аас явуулж буй Зүүн хүрээ коллежийн бичиг үсгийн багш М.Эрдэмбилэгийн заасан монгол бичгийн сургалтад цахимаар хамрагдаж үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшлүүлсэн. Үр дүн: Монгол бичгийн мэдлэг чадвараа дээшлүүллээ.	2025.01.02 2025.05.20	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЧАНАР ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)



(нэр, гарын үсэг)

/ Ц.БОЛОР-ОЮУН /

2025.05.19

(огноо)